

МӨРИЙН ГУРВАН ЭРХЭМ

Богд тойн багш нарт мөргөмүй

1. Бурханы эрхэм зарлиг бүхний шим утга,
Бодьсадва дээдэс нарын сайшаасан мөр,
Хувьт гэтлэхийг хүсэгчдийн орох оломыг
Хэр чадлаар би номлосугай
2. Сансарын амгаланд үл тачааж,
Чөлөө, учралын хэргийг гаргахад хичээснээр
Бурханыг баясгах мөрд сэтгэл итгэсэн
Хувьтан бүгд тунгалаг сэтгэлээр сонсохтун
3. Асар ариун магад гарахуй үгүйгээр сансарын далайн
Амгалангийн үрийг хүсэвч амирлах арга үгүй
Орчлонд шунаснаар амьтан бүгд
Огоот хүлэгдсэн тул магад гарахуйг эхэнд эрэхтүн
4. Чөлөө, учрал олдоход бэрх, насанд завгүйг
Сэтгэлдээ дадуулснаар энэ насанд шунахуйг буцаана
Үйлийн үр хуурмаггүй, орчлонгийн зовлонг
Үргэлж санаваас хойдын шунал буцна
5. Ийнхүү дадуулснаар орчлонгийн хотол чуулганд
Эгшин төдийд ч сэтгэл үл дурших ба
Өдөр, шөнөд гэтлэхийг хүссэн оюун төрвөөс
Өдгөө тэр цагт магад гарахуй төрнө
6. Магад гарахуй нь нэн ариун бодь сэтгэлээр
Машид эс эзлэгдвээс ханьцашгүй бодийн
Хотол чуулсан амгалангийн уг үл болох тул
Оюун төгөлдөрүүд бодийн дээд сэтгэлийг үүсгэ
7. Хүчирхүй бэрх дөрвөн мөрөний урсгалд автаж,
Тайлахуй бэрх үйлийн хүлээсээр чанга хүлэгдэж,
Басхүү би-д барихуйн төмөр торонд хоригдоод
Балар мунхагийн түнэр харанхуй бүрхсэн
8. Хязгаар үгүйеэ сансарын төрлөөс төрөлд
Тасралт үгүйеэ гурван зовлонд нэрвэгдэх
Энэ мэт энэлсэн эхүүдийн мөн чанарыг
Эгнэгт санан сэтгэлийн дээдийг үүсгэхтүн

9. Орших ёсыг оносон билгүүн үгүй бол
Магад гарах ба бодь сэтгэлийг дадуулсан ч
Орчлонгийн үндсийг таслаж үл чадах тул
Онож шүтэн барилдлагыг мэдэхүйн аргад шамд
10. Хэн бээр орчлон ба нирвааны юмс бүгдийн
Уг, үр хэзээд үл эндүүрдэгийг үзэх ба
Зоригдлын тушаа бүгдийг эвдэвээс
Тэр бээр Бурханыг баясгах мөрд орвой
11. Хуурмаггүй шүтэн барилдлагат үзэгдэл ба
Хоосныг зөвшөөрөх хагацсан хоёр ойлголт
Хэдий чинээнд тусдаа үзэгдэхийг хүртэл
Хэзээд Чадагчийн таалалыг үл ономуи
12. Хэзээ нэгэнтээ сөөлжих үгүйгээр нэгэн зэрэг
Хуурмаггүй шүтэн барилдлагыг үзсэн төдийд
Магад мэдлийн орны баригдах бүгдийг эвдэвээс
Магадтайяа тэр л цагт үзлийн нягтлал гүйцнэ
13. Басхүү үзэгдлээр буйн хязгаарыг арилгах,
Байхгүйн хязгаарыг хоосноор няцаах ба
Хоосон бээр уг, үрд ургах ёсыг мэдвээс
Хорт эцэслэн барих үзэлд үл булаагдах болой
14. Аяа, энэхүү мөрийн гурван эрхэмийн
Аньсыг өөрөө нарийвчлан мэдэх цагт
Аглагыг шүтэн хичээнгүйн хүчийг үүсгээд
Ашидын хэргээ түргэн бүтээхтүн, Хүү минь!

Хэмээх үүнийг олонтаа сонсогч гэлэн Лувсандагва бээр Цахойн ноён Агваандагвад захив.

Сарва манга лам.